

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА “АВРАЛЫН ЭРЭЛД” ХХК



СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ
ТАРХАЦ, НӨӨЦИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН
ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ, 2024 ОН



СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ, НӨӨЦИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Тайлан боловсруулсан:

“Авралын Эрэлд” ХХК-ийн

Агнуур зүйч

Ч.БҮҮВЭЙ

(Байгаль орчны гавьяат ажилтан)

Агнуур зүйч

М.ЗУЛБАЯР

Агнуур зүйч

С.БАТЗОРИГ

Улаанбаатар
2024

АГУУЛГА

ОРШИЛ.....	4
ҮНДЭСЛЭЛ.....	5
I БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, МОНГОЛ ТАРВАГАНЫ НӨӨЦ ТОГТООХ АРГАЗҮЙ, ОРОЛЦСОН БҮРЭЛДЭХҮҮН	6
1.1 СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО	6
1.2 СҮХБААТАР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ДАХЬ МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ, ТООЛЛОГО ХИЙСЭН АРГА ХЭЛБЭР	6
1.3 СУДАЛГААНД ОРОЛЦСОН БҮРЭЛДЭХҮҮН, ЗАМНАЛ.....	8
II БҮЛЭГ СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУР, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОГ.	10
2.1. БАЙРШИЛ, ГАЗРЫН ГАДАРГА.....	10
2.2. ХҮН АМ, МАЛ АЖ АХУЙ	11
2.3. БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ.....	12
III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН.....	16
3.1. СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТОО ТОЛГОЙ, НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ	18
3.2. СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ БАЙРШИЛ.....	23
ДҮГНЭЛТ.....	30
ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ.....	31
АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ.....	33
ХАВСРАЛТ 1. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ БҮРТГЭЛ	34
ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОЖ МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ХҮНИЙ НЭРС	37
ХАВСРАЛТ 3. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮЕИЙН ФОТО ЗУРАГ	38

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ХЭЭРИЙН СУДАЛГАА (МӨНХХААН СУМ).....	8
ЗУРАГ 2. СУДАЛГАА ХИЙСЭН ЗАМЛАЛ.....	9
ЗУРАГ 3. МОНГОЛ ОРНЫ АМЬТНЫ ГАЗАРЗҮЙН МУЖЛАЛ.....	10
ЗУРАГ 4. ЖИЛИЙН ДУНДАЖ ТЕМПЕРАТУР, ХУР ТУНАДАС.....	14
ЗУРАГ 5. МОНГОЛ ОРНЫ УРГАМАЛ ГАЗАРЗҮЙН ТОЙРОГ.....	15
ЗУРАГ 6. МОНГОЛ ТАРВАГА (MARMOTA SIBIRICA).....	16
ЗУРАГ 7. МОНГОЛ ОРНЫ ТАРВАГАНЫ ТАРХАЦ (2010 ОН).....	17
ЗУРАГ 8. МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ, НӨӨЦИЙН ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТ.....	19
ЗУРАГ 9. СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ 2024 ОН.....	20
ЗУРАГ 10. СЭРГЭЭН НУТАГШУУЛСАН ТАРВАГАНЫ МЭДЭЭЛЭЛ.....	22
ЗУРАГ 11. ТҮМЭНЦОГТ СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	23
ЗУРАГ 12. СҮХБААТАР СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	24
ЗУРАГ 13. ЭРДЭНЭЦАГААН СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	24
ЗУРАГ 14. ДАРЬГАНГА СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	25
ЗУРАГ 15. НАРАН СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	26
ЗУРАГ 16. ОНГОН СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	26
ЗУРАГ 17. ХАЛЗАН СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	27
ЗУРАГ 18. БАЯНДЭЛГЭР СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	28
ЗУРАГ 19. УУЛБАЯН СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	28
ЗУРАГ 20. МӨНХХААН СУМЫН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ.....	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ТАЛБАЙН ТООЛЛОГЫН МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТ.....	7
ХҮСНЭГТ 2. ЗАМНАЛААР ТООЛСОН МАТЕРИАЛЫН БОЛОВСРУУЛАЛТ.....	7
ХҮСНЭГТ 3. СҮХБААТАР АЙМГИЙН ХҮН АМ (2023).....	11
ХҮСНЭГТ 4. СҮХБААТАР АЙМГИЙН МАЛЫН ТОО (2023).....	12
ХҮСНЭГТ 5. ЖИЛИЙН ДУНДАЖ ТЕМПЕРАТУР, ХУР ТУНАДАС.....	13
ХҮСНЭГТ 6. СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ.....	21
ХҮСНЭГТ 7. ТАРВАГА ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ 1 ЖИЛЭЭР.....	32

ОРШИЛ

Манай оронд Алтай болон Монгол гэсэн хоёр зүйлийн тарвага бий. Тарвага нь ойт хээр, уулын хээр, тал хээрийн бүсэд өргөн тархсан бөгөөд газрын өнгөн давхрааг сийрэгжүүлэн хольж хөрсний бүрдэл бүтцийг сайжруулж ургамлан нөмрөгт асар их эерэг нөлөөг үзүүлдэг төдийгүй бүх мах идэшт хөхтөн амьтад, шувуудын идэш тэжээл болдог ач холбогдолтой. Монгол тарвага оршин амьдарч байгаа газар нутгийнхаа экосистемийн тогтолцооны чухал нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж экологийн тэнцвэрт байдалд гол үүрэг гүйцэтгэдэг амьтан юм. Сүүлийн жилүүдэд мөнгөний төлөө зарласан хэт их агнуур, байгалийн үзэгдэл, дэлхийн дулаарал зэрэг антропологи экологийн хүчин зүйлээс болж тархац нутаг нь хумигдаж, тоо толгой, нөөц эрс багассаар ихэнх нутгууд тарвагагүй болоод байна. Зах зээлийн нийгэмд шилжиж хүн бүр харагдсан тарвагыг толгой дараалан агнаж, зарим үед намар өвлийн заагаар ичээ үүрийг хөндөх зэргээр 10 хан жилд тарваганыхаа нилээдгүй хувийг дуусгасан. Тооцоо судалгаагүй агналтын зэрэгцээ идээшил нутгийн экологийн нөхцөл хүндэрч ган зуданд олноороо өртсөн байна. Тархац нутгийн зарим хэсэгт ган болж, тарга тэвээрэг муу авч өвөлжихөд шаардлагатай энергийн нөөц өөхөн давхаргыг хуримтлуулж чадахгүй өвөлдөө ичээ нүхэнд үхэх зэрэг нь тарваганы тоо толгой буурах, тархац нутаг тасархайтан хумигдах үндсэн шалтгаан болжээ. Нягтшил өндөр газраас өмнө нь тарвагатай байсан газар руу сэргээн нутагшуулах ажлыг зохион байгуулах нь уг амьтныг тархац нутагт нь хамгаалах, цаашлаад тухайн газрын экосистемийн эрүүл тогтвортой байдалд ихээхэн чухал.



ҮНДЭСЛЭЛ

Тарвага нь ойт хээр, уулын хээр, тал хээрийн бүсэд өргөн тархсан бөгөөд газрын өнгөн давхрааг сийрэгжүүлэн хольж хөрсний бүрдэл бүтцийг сайжруулж ургамлан нөмрөгт асар их эерэг нөлөөг үзүүлдэг төдийгүй бүх мах идэшт хөхтөн амьтад, шувуудын идэш тэжээл болдог ач холбогдолтой төдийгүй улс орны эдийн засаг болон ард түмний амьжиргаанд өгөөж сайтай, тэргүүн зэргийн ангийн нөөц баялаг болдог байна.

Монгол тарвага 2004-2007 онуудад Сүхбаатар аймгийн нутагт эрс ховордож Дарьганга сумын Шилийн богд, Энгэрийн ухаа, Талын ухаа зэрэг газруудад 300 гаруй толгойг эс тооцвол устах аюулд ороод байна. Өмнө нь тарвагагүй байсан Эрдэнэцагаан сумын нутагт 1969 онд тухайн үеийн эрдэмтэн судлаачид, орон нутгийн удирдлага тарвага сэргээн нутагшуулах ажлыг санаачлан хийж агнуурын нөөцтэй болтол өсгөсөн баримт байдаг байна. 2008-2009 оны үед Сүхбаатар аймгийн хэмжээнд маш цөөн тооны тарвага үлдсэн. Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас санаачлан 2009, 2011, 2012 онуудад орон нутгийн төсөв хөрөнгө, гадны зээл тусламжтайгаар Хэнтий аймаг, Төв аймгуудын нутгаас тарвага сэргээн нутагшуулах ажлыг дэс дараатай хийсний үр дүнд одоогийн байдлаар Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт, Эрдэнэцагаан, Дарьганга, Онгон, Халзан, Уулбаян, Мөнххаан зэрэг сумдын нэр бүхий газруудад өсөн үржиж байна. Сүхбаатар аймгийн хэмжээнд тарваганыхаа тархац тоо толгойн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байгаа нь цаг үеэ олсон онцгой чухал ажлын нэг болсон нь ажлын шаардлага амьдралаас урган гарч байна.

I БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, МОНГОЛ ТАРВАГАНЫ НӨӨЦ ТОГТООХ АРГАЗҮЙ, ОРОЛЦСОН БҮРЭЛДЭХҮҮН

1.1 СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

Сүхбаатар аймгийн монгол тарваганы тоо толгойн нөөц, тархац, байршлыг тогтоох. Цаашид хамгаалах, өсгөн үржүүлэх нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй сайжруулах, менежмент төлөвлөлтийн урьдчилсан судалгаа хийх зорилготой. Зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж ажиллав.

- Монгол тарваганы тархцын зураглал үйлдэх
- Хуучин тарвагатай газрын тарваганы тархац нөөцийн үнэлгээг хийх
- Шинээр сэргээн нутагшуулсан тарваганы тархац нөөцийн үнэлгээг хийх.

1.2 СҮХБААТАР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ДАХЬ МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ, ТООЛЛОГО ХИЙСЭН АРГА ХЭЛБЭР

Тарваганы нөөц тогтоох олон арга зүй байдгаас бид дараах хоёр аргыг тарвага тархсан сумдад ашиглав.

ТАЛБАЙН АРГА. Нэгдүгээр үе: Тооллого хийх газрын гадаргуугаас шалтгаалах, тарваганы тархалтын байдал их, бага талбайд тархсан, нягтаршил зэргээс хамаарч талбайн хэмжээг янз бүрээр тогтоон авч болно. Тарвага өргөн уудам талбайд нягтшилыг харгалзан талбайгаа ихэвчлэн 5-30га (500*100), (250*200) гэх мэт сонгоно. Талбайг сонгон авсны дараа тэгш талбайд ногдох тарваганы бүлийн тоог (Хүснэгт 1) тогтооно. Жишээ нь: тооллогын 20 га талбайд 8 бүл тарвага байсан гэвэл 1га-д (бүл:20га) 0.4 бүл ногдож байна.

Хоёрдугаар үе: Сонгон авсан талбайн тарваганы гарааны хамгийн идэвхтэй үед дурандаж бүл тус бүрийн тарвагыг зөв тоолж нэг бүл дэх тарваганы дундаж тоог гаргана. Жишээ нь: Тооллогын талбайн 5 бүлд тус бүр 4+6+6+5+6 бүгд 26 тарвага байсан бол нэг бүлд дунджаар 5.2 (26:5) ноогдож байна. Үүнээс нэг га дахь тарваганы нягтшилыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд: Нэг га-д байгаа бүл 0,4-г нэг бүл дэх тарваганы дундаж тоогоор үржүүлж ($0.4 \times 5.2 = 2.1$) га-д ногдох (2.1) тарваганы тоог гаргана. Энэ нь ам дөрвөлжин км талбайд 210 тарвага байна гэх мэтчилэн өдөр бүрийн тооллогын материалыг (Хүснэгт 1) дагуу боловсруулдаг.

Талбайд ногдох дундаж хэмжээг тогтоосон учир цаашид тооллогын талбай бүрийн тарвагыг тоолох шаардлагагүй харин өдрийн дүнг нэгтгэн нягтшилыг тодорхойлдог.

Хүснэгт 1. Талбайн тооллогын материал боловсруулалт

№	Тооллого хийсэн газар	Тооллогын талбай	Тарваганы бүл		Тарвага тоолсон бүл	Бүл дэх тарвага	
			Бүгд	Га-д ногдох (3:2)		Бүгд	Нэг бүлд ногдох тарвага
1					5	26	5.2
2							
3							

ЗАМНАЛЫН АРГА. Энэ аргаар том хэмжээний талбай бүхий тал, хөндийн тэгш гадаргуутай нутгийн тарвагыг тоолно. Тооллогыг машин, мотоцикл, морь болон явган явж хийнэ.

Нэгдүгээр үе: Тоологчид тарваганы тархац нутаг дундуур эгнээ хоорондын зайг 200-400 м -ийн зайтай 1-5 км-ийн тууш өргөн зурвастай явж тарваганы бүлийг тодорхойлно. Аль болохоор шулуун явах шаардлагатай байдаг.

Хоёрдугаар үе: Дараа нь талбайн аргын нэгэн адил нэг бүлд ногдох тарваганы дундаж тоог тогтооно. Тоологчийн материалыг (Хүснэгт 2) дагуу боловсруулна.

Хүснэгт 2. Замналаар тоолсон материалын боловсруулалт

№	Газрын нэр	Тооллогын зурвас		Талбайн хэмжээ (га)	Тоологдсон тарваганы бүлийн тоо		Бүл дэх тарваганы тоо	Бүл дэх тарвага	
		Урт	Өргөн		Бүгд	Га-д ногдох		Бүгд	Нэг бүлд оногдох
1									
2									
3									

Тарваганы тархац нь уулын хээрийн бүсийн тал хөндийн ухаа, толгодын ар өвөр, гуу жалга, уулын бэл, энгэр толгодын хооронд бие биеэс тусгаарлагдсан бүл тарвагатай. Энэ нь нутгийн одоогийн тархалт юм. Ухаа хэц толгод, гуу жалгын дэнж, уулын өвөр талын ба бэлийн ботууль, биелэг өвс, ганга, уул өвс, хялгана, шивээ, үетэн элдэв өвст, карбонатгүй хээрийн болон тал хээрийн саарал хөрс зонхилсон босоо бүслүүрт далайн түвшингээс дээш 1062-1778 м өндөрт тарвага нутагладаг нь бидний судалгаагаар тогтоогдлоо.

Тарваганы судалгааг хийхдээ тарваганы нөөц тогтоох арга зүй заавар, дүрэм журмын дагуу явуулсан боловч зарим газрын тарваганы тоо толгойн хэмжээ, газар нутагт тархсан тархалтын хэмжээ, хязгаарын талбай судалгааны аргазүйн хэлбэрт зохицолдохгүй учраас нэгж талбайн хэмжээнд нэг бүрчлэн хайгуулын аргаар явж, нэг бүрчлэн ичээ нүх, зусаал нүхийг тоолон нүхний тоо хэмжээг

хэдэн нүхэнд хэдэн амьтан зун, хавар, намар орогнон амьдардаг, нэг бүлд хэдэн амьтан амьдарч байсан зэргийг амьдралын шинж, дош нүхний байдал, гүйдэл зам, мөр, хэвтэш, сүүдрэвч, баас (нүхнээс баасны хол ойрын хэмжээ), ичээ нүх зусаал нүхнээс хол ойрын хэмжээ, зусаал нүх, дошинд байгаа ичээ, шинэ бүл үүссэн байдал, аваарын нүхний тоо (жижиг том), эх бүл дошноос хол ойр зай зэргийг нарийн ажиглан бүл дэх тоо, тарваганы том жижгийг тогтоохоос гадна гарааны идэвхтэй үед бүлийн тоо, бүлийн нас, том, төл зэргийг тогтоосон болно. Тарваганы 1км² (100га) талбайд оногдох тоо толгойг (нягтшил) тогтооход сорил талбайн арга, замналын аргыг Хар ямаат, Шилийн богдод хэрэглэсэн болно.


1.3 СУДАЛГААНД ОРОЛЦСОН БҮРЭЛДЭХҮҮН, ЗАМНАЛ

Сүхбаатар аймгийн монгол тарваганы тархац нөөцийн судалгааны хээрийн ажлыг 2024 оны 09 сарын 10-ны өдрөөс эхлэн 09 сарын 24 хүртэл монгол тарваганы тархац бүхий 10 сумын нутгаар талбайн арга болон заналын аргыг ашиглан 36хүн/хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.

Багийн бүрэлдэхүүн: Сүхбаатар аймгийн 10 сумын 2713 км замналыг Ч.Бүүвэй (*Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Авралын Эрэлд” ХХК, ЭША*), М.Зулбаяр (*Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Авралын Эрэлд” ХХК, агнуур зүйч*), С.Батзориг (*Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Авралын Эрэлд” ХХК, агнуур зүйч*), Б. Эрдэнэбаяр (*Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн*). Мөн сумдын байгаль хамгаалагчид, Байгаль орчны улсын байцаагчид, нутгийн иргэд бидний судалгаанд анкетын судалгаа, газар нутгаа заах зэргээр оролцсон болно.



Зураг 1. Хээрийн судалгаа (Мөнххаан сум)




Зураг 2. Судалгаа хийсэн замнал

Байгалийн өвөрмөц тогтоцтой газар элбэг бөгөөд Дарьганга Онгон суманд 200 гаруй сөнөсөн галт уулс 127-248 хавтгай километр талбай эзэлнэ. Онгон суманд Молцогийн их элс, Дарьганга Наран сумын нутагт Баян дулаан, Талын агуй, Мөнххаан сумын Баян-Уул орчмын 70 гаруй агуй, Лог, Будар, Зараа, Дэлгэрхаан, Харгилтай зэрэг үлэмж талбай бүхий чулуун тогтоцтой нуруу хөндий олонтой. Сүхбаатар аймгийн 7 гайхамшгаар Алтан-Овоо, Шилийн богд, Монголын хүн чулуу, Таван толгой археологийн цогцолбор, Ганга нуур ба Оргихын булаг, Хунгийн чуулган, Егүзэр хийд зэрэг газар багтжээ.

2.2. Хүн ам, мал аж ахуй

Засаг захиргааны нэгжийн хувьд 13 сум, 67 багийн 19.5 мянган өрхтэй ба 65.9 мянган хүн амтай. Нийт өрхийн 10.5 мянга (53.8%), хүн амын 36.1 мянга (54.8%) нь аймаг, сумын төвд амьдарч байна. Хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амыг насны ангиллаар авч үзвэл 0-14 насны хүн ам 21.5 мянга (32.7%), 15-34 насны хүн ам 18.4 мянга (27.9%), 35-59 насны хүн ам 20.3 мянга (29.6%), 60 ба дээш насны хүн ам 5.6 мянга (8.5%) болж, хүн ам зүйн ачаалал 60.4 хувьтай байна. Аймгийн хэмжээнд хамгийн их өрх, хүн амтай Баруун-Урт сумын 1-р баг 1156 өрх, 3983 хүнээр 67 баг дотор тэргүүлж байгаа бол хамгийн бага өрх, хүн амтай нь Халзан сумын 2-р баг 91 өрх, 222 хүнтэй байгаа юм. Аймгийн хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 34.7 хувь Баруун-Урт хотод, 10.8 хувь Эрдэнэцагаан суманд, 8.0 хувь Баяндэлгэр суманд, хамгийн бага 2.6 хувь Наран суманд, үлдсэн 43.9 хувь бусад суманд оршин сууж байна. Аймгийн хүн амыг насны ангиллаар эзлэх хувь хэмжээг зургаар харуулав.




Хүснэгт 3. Сүхбаатар аймгийн хүн ам (2023)

2023 онд 11.4 мянган өрх, 55 аж ахуй нэгж, байгууллагад нийтдээ 3.9 сая толгой мал тоолууллаа. Нийт малтай өрхийн дотор мал бүхий 2.4 мянган өрх, малчин 9.0 мянган өрх, тавиул малтай 83 өрх байна. Мал аж ахуйн салбарт 15.6 мянган малчид ажиллаж байна. Энэ онд 656 өрх мянгаас дээш мал тоолуулсан бол шинээр 44 өрх мянгаас дээш мал тоолуулжээ.

Нийт малтай өрхийн 46.9 хувийг 200 хүртэлх, 30.5 хувийг 201-500 хүртэлх малтай өрх, 22.6 хувийг 501 дээш малтай өрх эзэлж байгаа нь 200 хүртэлх малтай өрх урьд оноос 14.4 хувиар, 201-500 хүртэлх малтай өрхийн тоо урьд оноос 2.1 хувиар өссөн бол, 501 дээш малтай өрх 22.8 хувиар буурсан байна. 2020 оны мал тооллогын урьдчилсан мэдээгээр 67061.1 сая тоо толгой мал, 241989 малчин өрхтэй бөгөөд 2019 оныхоос 3.9 сая (5.5%) буурсан байна.

Мал сүрэг урьд оноос 785.3 мянган толгойгоор буурч, 3.9 сая толгой мал хүрсний дотор тэмээ 7.6 мянга, адуу 366.3 мянга, үхэр 303.5 мянга, хонь 2.0 сая, ямаа 1.2 сая толгой болжээ. Аймгийн хэмжээнд 498.7 мянган толгой малаараа Эрдэнэцагаан сум тэргүүлж байна. Малын төрлөөр авч үзвэл адуу 60.1 мянган толгой, үхэр 41.9 мянган толгой, ямаа 184.0 мянган толгой малаар Эрдэнэцагаан сум, 1.4 мянган толгой тэмээгээр Түвшинширээ сум, 263.2 мянган толгой хониор Сүхбаатар сум аймагтаа тэргүүлж байна. 2023 онд 1.8 сая хээлтэгч мал тоологдож өмнөх оноос 204.1 мянган толгой малаар буюу 9.9 хувиар хээлтэгч мал буурсан байна.

Малын нийт сүргийн бүтцийн 44.8 хувийг хонь, 41.3 хувийг ямаа, 6.1 хувийг адуу, 7.1 хувийг үхэр, 0.7 хувийг тэмээ эзэлж байна. Малын тоо өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.



Хүснэгт 4. Сүхбаатар аймгийн малын тоо (2023)

2.3. Байгаль, цаг уурын нөхцөл

Сүхбаатар аймаг нь газар зүйн байршлын хувьд Монголын Дорнод талын их мужид багтах бөгөөд нийт нутгийн 78.3 хувь тал хээрийн бүс, 21.7 хувь говь хээрийн бүсэд багтдаг. Монголын Дорнод талын их муж нь 247630 км² талбайтай ба Дундад Халхын өндөрлөг, Дарьганга, Дорнодын тэгш тал гэсэн гурван дэд мужаас тогтоно. Энэ мужийн онцлог нь ухаа гүвээт, тэгш талуудтай. Дундаж өндөр нь 600-900 метр орчим өргөгдсөн, хуурай хээрийн ландшафтай.

Монгол улсын Үндэсний атлас дахь уур амьсгалын мужлалын зургаас харахад тус аймгийн хойт ба өмнөд нутаг нь Хуурайдуу сэрүүн зунтай, хахирдуу өвөлтэй мужид, нутгийн дунд хэсгийн аймгийн төвийг дайрсан зурвас газар Хуурай, сэрүүвтэр зунтай, хахирдуу өвөлтэй мужид, урд хилийн дагуух зурвас нутаг чийглэгдүү, сэрүүвтэр зунтай, хахирдуу өвөлтэй мужид тус тус багтдаг.


Сүхбаатар аймгийн агаарын температурын сарын дундаж утга болон жилд унах хур тунадасны хэмжээг <https://en.climate-data.org>) цахим сувгаас шууд авч боловсруулалт хийсэн болно.

Агаарын температур. Баруун-Урт дахь агаарын дундаж температур 1.9 °C бол хамгийн сарын дундаж температур 16.4 °C байна. Харин хамгийн сэрүүн сарын дундаж температур -14.1 °C байна. Хамгийн бага тунадас унадаг сар бол 1 сар бөгөөд 0.7 өдөр харин хамгийн их тунадас унадаг сар бол 7 сар бөгөөд 10 өдөр байна. Энд 271 мм орчим хур тунадас ордог байна.

Хүснэгт 5. Жилийн дундаж температур, хур тунадас

Температур, хур тунадас	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Дундаж температур (°C)	-19.7	-14.8	-5	3.8	11.5	18.2	20.9	18.8	12.2	2.3 °C	-8.6	-16.8
Бага температур (°C)	-25.5	-22.1	-11.2	-2.4	4.6	11.8	15	12.7	6.1	-2.9	-13.5	-21.7
Их температур (°C)	-13.6	-8.1	1.2 °C	10.3	18.2	24	26.6	24.7	18.4	8.2	-3.5	-11.8
Хур тунадас (мм)	3	4	7	14	27	47	66	49	30	13	7	4

Жилийн хамгийн дулаан сар нь 7-аар сар бөгөөд дундаж температур 20.9 °C байна. 1-ээр сард дундаж температур 19.7 °C байна. Энэ нь хамгийн бага дундаж температур юм. Харьцангуй чийгшлийн хувьд 1-р сар 33.61 хувьтай хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Харин эсрэгээр дөрөвдүгээр сард харьцангуй чийгшил хамгийн бага буюу ердөө 33.61 болж бүртгэгдсэн байна.



Зураг 4. Жилийн дундаж температур, хур тунадас

Ландшафт. Ландшафтын мужлалтаар ихэнх нутаг нь Дагуур-Монголын хээрийн их мужид хамрагдах хэдий ч Төв Азийн заримдаг цөл, цөлийн их мужийн нутаг зүүн хэсгээр тохиолдоно. Монгол орны геоморфологийн мужлалаар Төв Азийн геоморфологийн их мужийн Монголын Дорнод мужийн Баруун-Уртын дэд мужид, хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн Хангайн мужид, ургамал газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн их мужийн Дагуур Монголын дэд их мужийн Монголын хээрийн мужид, байгалийн бүс, бүслүүрийн хувьд Монгол орны хээрийн бүсийн дэд бүсэд тус тус хамрагдана.

Газар нутаг нь ихэнхдээ нам уулс, ухаа гүвээт талархаг гадаргатай. Аймгийн нутгийн хойт, баруун хойт хэсэгт эгцэвтэр хажуутай, шовх оройтой Мөнххааны бэсрэг уулс, гүвээ толгод тохиолдох ба урагшлах тутам тэгш талархаг газар үргэлжилэн, өмнөд хэсэгтээ Дарьгангын галт уулсын муж болох Монголын дорнод талын хамгийн өндөр хэсэг болох өндөрлөг уулс бүхий уулт хээр оршино.


Нутгийн өмнөд хэсэгт Онгон, Молцог зэрэг баруун хойшоо сунаж тогтсон элсэн манханы захаар булаг ундарч, зарим хотгорын ёроолд тунгалаг устай нуур тогтсон байдаг байна. Сүхбаатар аймгийн нутгийн хойд болон зүүн хэсэг нь Номхон далайн ай савд бусад хэсэг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарахын зэрэгцээ гадаргын урсац сарних бүсэд оршдог. Иймд тус ай савын гадаргын усан сүлжээ нь хэмжээгээрээ нилээд бага, тэдгээрийн гадаргын урсацын байгалийн горим нилээд тогтворгүй, ихэвчлэн хатаж ширгэдэг онцлогтой.

Сүхбаатар аймгийн ургамал, газар зүйн мужлал. Академич Н.Өлзийхутаг (1989) Монгол орны нутаг дэвсгэрийг ботаник-газарзүйн 16 тойрогт хуваасан байдаг. Энэ мужлалаар Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр дараах 3 тойрогт хуваагдана. Үүнд:

- Дундад Халхын хээрийн тойрог
- Дорнод Монголын хээрийн тойрог
- Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог



Монгол орны ургамал газарзүйн тойргууд Н.Өлзийхутаг, 1989



Зураг 5. Монгол орны ургамал газарзүйн тойрог

Дундад Халхын хээрийн тойрог. Энэ тойрогт Баруун-Урт хотоос хойшхи нутаг хамрагдах ба ургамлын аймгийн хувьд биеэ даасан өвөрмөц онцлог багатай, хэд хэдэн тойргийн шилжих зааг дээр байрлах учир Төв Азийн Монгол хошуу болоод Дагуурын хээрийн, зарим нь цөлөрхөг хээрийн бас умардын уулсын элементүүд оролцоно.

Дорнод Монголын хээрийн тойрог. Энэ тойрогт Баруун-Урт хотоос урагших нутаг хамрагдах ба умард зүгээс дагуурын хээр, өмнө зүгээс Төв Азийн Монгол хошууны ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан нийлж буй шилжилтийн бүс таардаг байна.

Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрог. Энэ тойрогт тус аймгийн Дорноговь аймагтай хиллэх баруун урд багахан хэсэг хамрагдах бөгөөд энд жинхэнэ цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн ургамлын аймагтай.

III БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Манай оронд алтайн тарвага (*Marmota baibacina*), монгол тарвага (*Marmota sibirica*) хэмээх хоёр зүйл тархсан бөгөөд Сүхбаатар аймгийн нутагт зөвхөн монгол тарвага тархсан байна.


Таних шинж: Нас бие гүйцэж, хүч тарга гүйцэд авсан Монгол тарваганы биеийн жин ойролцоогоор 10 кг, биеийн урт 65 см хүрнэ. Үзүүр хэсэг нь бараан 90-160 мм урт сүүлтэй хадны ангал, нүх хөндий, ганга налууд чадмаг авирна. Толгой тавшгар, дагз хар, хүзүү богино, чих хулгар, хөдөлгөөн болхи амьтан. Нүд нь гавал ясан дээр байрлалтай тул нүхнээс цухуймагц орчны байдлыг ажиглан харах чадвартай болжээ. Үнэр, харааны эрхтэн сайн хөгжсөн. Шанаа, хоншоор, эрүү, нүдний орчим байх 3-6 см урт олон тооны мэдрүүл үс нь харанхуй нүхэнд орж, гарахад мэдээлэл өгөх гол үүрэг гүйцэтгэнэ. Мөчид хүчирхэг, урд мөч тав, хойд мөч дөрвөн хуруутай. Хумс бахим, мохоо, хүчирхэг.

Хамгааллын статус: Олон улсын үнэлгээ (IUCN, 2010) болон бүс нутгийн үнэлгээ (IUCN, 2006)-ээр устаж болзошгүй зүйл (endangered species) ангилалд тус тус хамрагдсан. Үндэсний хэмжээнд Байгаль орчны яамны сайдын тушаалаар 2005, 2006 онд орон даяар тарваганы агнуурыг бүрэн хориглосон. Монгол тарваганы тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдсан.



Зураг 6. Монгол тарвага (*Marmota sibirica*)

Монгол тарвага нь манай орны уулын хээрт зонхилж хойд талын хөвч тайга, урд талын говь, цөлийн бүс хүртэлх уудам зурвас нутагт далайн түвшнээс 800-3800 м өндөрт тохиолдоно. Төв Азийн эрс тэс хуурай уур амьсгал бүхий өвөрмөц экологийн нөхцөлтэй Монгол орны умард өргөргийн 44°-52°, зүүн уртрагийн 90°-120° -ийн хооронд илүү ихээр идээшин зохилджээ (Адьяа, нар 2016). Монгол Алтайн нуруу, Хэнтийн нуруу, Хангайн нуруу, Дундад Халхын уулс, Хан Хөхийн уулс, Их Хянган, Говь Алтайн нурууны салбар уулсын ойгүй уулын хээр, дорнод Монголын хялганат ухаа гүвээрхэг хээр, талархаг хээр, хуурай хээр, нугархаг хээр, умард говийн хад чулуут тусгаар хад чулуурхаг уулсаар тохиолдоно (Зураг 7).



Зураг 7. Монгол орны тарваганы тархац (2010 он)

1970-аад оны үед тарваганы тархац нутаг нь Монгол орны газар нутгийн ойролцоогоор 68 хувь буюу 1.07 сая километр квадрат талбай бүхий нутгийг хамарч байжээ. 2002 онд зүүн бүсэд хийсэн судалгаагаар тус бүс нутгийн хэмжээнд Монгол тарваганы тархац ихээхэн хумигдсан болохыг тооцоолж гаргасан бөгөөд нийт нүхний 5 хувь нь л идэвхтэй байснаас үзвэл Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн газар нутгийн хэмжээнд 159,000 орчим тарвага үлдсэн байх боломжтой байна. 2007-2009 онуудад хийсэн судалгаагаар Монгол орны тарваганы нийт тоо толгойг 8 сая хэмээн үнэлсний 88 хувь (7 сая) нь Монгол тарвага, үлдэх 12 хувь (930,000) нь Алтайн тарвага байна гэсэн үр дүн гарчээ. Тус тайланд дурдсанаар Монгол орны байгаль хамгийн тааламжтай нөхцөл дор 8 сая

гэж тооцож гаргасан тооноос гурав дахин олон тарвагыг (21 сая) тэтгэх боломжтой байна (Лондоны амьтан судлалын нийгэмлэг, 2019).


1986-1989 онд Монгол орны нутаг дэвсгэрт 16 аймгийн 229 сумын нутагт 251172.18 км² талбайд 23 сая тарваганы нөөцтэй байсан ба 2010 оны судалгаагаар тарвагатай талбайн хэмжээ 134 963.58 км² болж 20 жилийн хугацаанд тарваганы тархац нутаг 1.86 дахин багассан байна (Тодгэрэл, 2013).

3.1. СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТОО ТОЛГОЙ, НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ

Судалгааны дүнгээс үзвэл Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт 17921.02 км² талбайд тарвага тархан байрших экологийн нөхцөлтэй болох нь тогтоогдсон бөгөөд сэргээн нутагшуулсан болон судалгаагаар ажиглагдсан монгол тарваганы дүнд үндэслэн үзвэл 1758.3 км² нутагт 698±34 толгой тарвага идээшин нутагладаг нь тогтоогдлоо. Эдгээр тарвага тархсан нутгийн талбайд 100 га буюу 1 км² талбайд дунджаар 0.39 тарвага ноогдох нягтшилтай байна (Сүхбаатар аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын тайлан. Эко үйлчилгээ ТББ 2014).

Нутгийн иргэд, байгаль хамгаалагчдын мэдээлэл, өөрсдийн хээрийн судалгаанд явсан маршрутын дагуух материалыг боловсруулахад 2021 оны 9-р сарын байдлаар Сүхбаатар аймгийн 6 сумын нийт 293.4 км² талбайд 110 бүлд нийт 365±28 орчим бодгаль монгол тарваганы нөөцтэй. Биднийг судалгаа хийх үед тодорхой шалтгаанаас (цаг агаар, дуу чимээ, дайсан амьтан) монгол тарвага ажиглагдахгүй байх магадлалтай учир 300-500 гаруй тоо толгой байх магадлалтай байна (Сүхбаатар аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын тайлан. “Авралын Эрэлд” ХХК 2021).


Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Богд уул, Мөнххаан уул, Дарьганга сумын Шилийн богд уул, Талын агуй, Талын ухаа, Цавчирын толгодод бүгд 454 га талбайд 914.3 орчим тарвагатай нягтшил 10 га талбайд 3.7 тарвагатай, нэг бүлд 4,1 бодгаль амьтнаар тооцогдсон, дараа нь Түмэнцогт сумын Хар ямаат уулын Чонотын ам, Баян-овоо, Лхүмбэ баг, багийн урд хэсгээр бүгд 472 га талбайд 209 бодгаль тарвагатай, хамгийн цөөн нь Уулбаян сумын үзүүр хараас жонштойн хөр 2 га талбайд 25 бодгаль тарвага байна. Бусад сумдын тарвага тархсан нутаг тоо толгойн үнэлгээг нөөцийн үнэлгээг (хүснэгт 6) тусгав. Бид судалгаандаа бүлийн болон бүл дэх тарваганы тоог тогтоохдоо 3157 зусаал нүх, 528 ичээ нүхний хэмжээ, шороо гаргалт, нүх засалт, бурхи, нагай, тарчийн ичэлтийн хол ойр зай (дошноос) зэргийг нарийн ажиглан, нягтлан судалж, судалгааны арга зүй, материал боловсруулахад ашиглав.



Зураг 8. Монгол тарваганы тархац, нөөцийн харьцуулсан үзүүлэлт

Дээрх судалгаанууд зорилго зорилтоосоо хамааран аймгийн хэмжээнд тархсан монгол тарваганы тархац нөөцийн мэдээг гаргаж байжээ. Эко үйлчилгээ ТББ болон манай байгууллагын өмнө хийсэн судалгаанууд Амьтны тухай хуулийн дагуу аймаг, нийслэл харьяа газар нутагтаа 5 жил тутам агнуурын ач холбогдолтой амьтдын тархац нөөцийн судалгаа буюу Ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежмент төлөвлөгөө боловсруулах ажил юм.

Түмэнцогт сумын Түмэнцогт уул, Хар ямаат, Чонотын ам, Баян-овоо уул, Лхүмбэ баг, Сүхбаатар сумын Хар ганга, Хавцал тогой, Баянцагаан овоо, Дөхмийн уурхай, Хонгор уул, Эрдэнэцагаан сумын Чандмань уул, Хурангын уул, Зотол хан уул, Дарьганга сумын Шилийн богд, Талын агуй, Талын ухаа, Баруун нарт уул, Наран сумын Баян дулаан уул, Бүдүүн толгой, Онгон сумын Онгон таван уул, Халзан сумын Самын ухаа, Тарвагатай, Баяндэлгэр сумын Шар даравгай, Хонгор баг, Адуун нутаг, Уулбаян сумын Жонштын хөр, Мөнххаан сумын Өлзийт овоо, Гутангийн айраг, Богд уул, Мөнххаан уул, Шилийн холбоо, Баянцагааны тал зэрэг газруудаар тархалттай байна.



Зураг 9. Сүхбаатар аймгийн монгол тарваганы тархац 2024 он

Тарваганы нөөцийн үнэлгээг харьцангуй бага алдаатай тогтоохын тулд тооллогын талбайн хэмжээ нийт тархац нутгийн 80-90 хувиар тооцоолж хайгуул судалгааг явууллаа. Тарваганы судалгааг сум тус бүрээр тооцоолж гаргав. Энэ нь тухайн талбайд урд өмнө нь хавар, зун, намар ганц нэг дош, нүх, тарвага харагдаж байсан гэсэн байгаль хамгаалагч, байцаагч, нутгийн хүмүүсийн мэдээлснийг анализ судалгаа хийн нарийвчлан тооцоо гаргав. Аймгийн нийт 10 сумын бүгд 6899.2 га талбайд 2733 орчим бодгаль тарвага идээшин нутаглаж байгаа тооцоо гарлаа. Тарваганы тархац маш сийрэг дош хоорондын зай болон бүл хоорондын зай ойр нь 200-300 м хол нь 1100-1350 м орчим зайтай учир сорилын талбайг 10 га-аар авсан.

Хүснэгт 6. Сүхбаатар аймгийн монгол тарваганы нөөцийн үнэлгээ


№	Сумдын нэр	Талбайн тоо	Нийт тархсан талбай (га)	Тоологдсон бүл тарвага	Тарваганы тоог тогтоосон бүл	10 га-д оногдох бүл	Тоологдсон бүл дэх тарвага	Нэг бүлд оногдох тарваганы тоо	Тарваганы нөөц
1	Баяндэлгэр	4	2370	44	12	0.5	63	5.3	238
2	Дарьганга	8	1425	232	50	3.5	239	4.1	1151
3	Мөнххаан	7	743.2	57	14	1.9	82	5.4	422
4	Наран	2	13	5	1	3.8	3	3	15
5	Онгон	4	10	12	4	11.2	14	5	50
6	Сүхбаатар	5	283	56	11	5	52	4.4	266
7	Түмэнцогт	6	809.5	55	11	6	58	4.8	345
8	Уулбаян	1	43	13	1	3	4	5	65
9	Халзан	5	1202	20	7	2.5	37	5.2	180
10	Эрдэнэцагаан	4	131	27	10	2.8	13	5.0	138
Нийт дүн			6899.2	523	114	4.2	558	4.6	2733

Түмэнцогт сумын Хар ямаатын Чонотын ам, Лхүмбэ багаас нэлээд урд хэсэг газарт, Сүхбаатар сумын Хар ганга, Эрдэнэцагаан сумын Зотол хаан уул, Дарьганга сумын Шилийн богд, Халзан сумын 1-р багийн нутагт тарвага өсөлттэй байна. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн тарваганы тархацтай 10 сумын нийт 6899.2 га талбайд 2733 толгой тарваганы нөөцтэй гэж тогтоогдлоо.

Тарваганы баялаг нөөцтэй байсан газар уул уурхай, газар тариалан, хөдөө аж ахуй, мал аж ахуй эрчимтэй хөгжүүлэх, малын тоо толгой хэт өсөж малын бэлчээр, малчдын суурьшил тарваганы тархац нутгийг эзэмших болсноор амьдрах орчны зохилдлогоо алдагдаж байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн 6 жилд монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг тасралтгүй гүйцэтгэж байгаа нь бусад орон нутагтай харьцуулахад өндөр дүнтэй байна. Сэргээн нутагшуулсан газар нутагт хяналт, хамгаалалт сайн байвал энэ зүйл амьтан түүхэн тархац нутагтаа дасан зохицож нутагших боломжтой гэдгийг давхар харуулж байна. Халзан сум 2010 оноос хойш тарвагагүй болсон газар нутагтаа шинээр сэргээн нутагшуулсан нь амжилттай болж тоо толгой өсөж байна. Хяналт мониторинг, эргүүл шалгалтыг байнга хийж нутагшиж байгаа үр дүнгээ хөдөлгөөн мэдрэгч бүхий автомат камераар хянаж байгаа сайн туршлага байна. Уулбаян сум тарваганы тархац, тоо толгой эрс багассан, устах аюулд хүрсэн популяцийг дэмжих зорилгоор сэргээн нутагшуулах ажлыг зохион байгуулж ажилласан байна. Дарьганга сумын Баруун нарт ууланд өмнө нь тарвага байгаагүй шинэ газарт сэргээн нутагшуулсан. Энэ орчмын тарвага амжилттай нутагшиж байгааг хөдөлгөөн мэдрэгч камер байрлуулж баталгаажуулсан байна.

Түмэнцогт сумын Хар ямаатын Байгалийн нөөц газарт анх 2019 онд сэргээн нутагшуулсан байршилдаа жил бүр нэмж нутагшуулж байгаа нь үр дүнгээ өгч тархац нутгаа тэлэх хандлага ажиглагдаж байна.




Зураг 10. Сэргээн нутагшуулсан тарваганы мэдээлэл

3.2. СҮХБААТАР АЙМГИЙН МОНГОЛ ТАРВАГАНЫ ТАРХАЦ БАЙРШИЛ


Сүхбаатар аймгийн хэмжээнд 10 сумын нутагт Монгол тарвага ямар нэг байдлаар тархсан байна. Тэдгээр 10 сумын тарваганы тархцыг зураглалыг үйлдэв. Түмэнцогт сумын Түмэнцогт уул, Хар ямаат, Чонотын ам, Баян-овоо уул, Цэмүүл голын зүүн тал, Хөшөө өндөр, Лхүмбэ багийн төмөртэй өндөр, багаас урагш бууцтай ам гэх газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 345 орчим тарваганы нөөцтэй байна.

Түмэнцогт суманд 2019-2024 он хүртэл 6 жилийн хугацаанд Хар ямаат БНГ, Хөшөө өндөр зэрэг газруудад Хустайн нурууны БЦГ-аас сэлгэн нутагшуулсан байна.




Зураг 11. Түмэнцогт сумын монгол тарваганы тархац

Сүхбаатар сумын Хар ганга, Хавцал толгой, Баянцагаан овоо, Баянцагааны тал, Дөхмийн уурхайн баруун болон зүүн тал, Хонгор уул гэх газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 266 орчим нөөцтэй байна. Сүхбаатар суманд 2019, 2022, 2023 онуудад Хар ганга, Баянцагааны тал зэрэг газруудад Хустайн нурууны БЦГ-аас сэлгэн нутагшуулсан байна.




Зураг 12. Сүхбаатар сумын монгол тарваганы тархац

Эрдэнэцагаан сумын Чандмань уул, Хурангын уул, Зотол хан уул гэх газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 138 орчим тарваганы нөөцтэй байна. Тус суманд 2019, 2023 онуудад 2 удаа Зотол хан уул, Ханан сүүдэр зэрэг газруудад Хустайн нурууны БЦГ-аас сэлгэн нутагшуулсан байна.




Зураг 13. Эрдэнэцагаан сумын монгол тарваганы тархац

Дарьганга сумын Шилийн богд, Талын агуй, Талын ухаа, Баруун нарт уул, Цавчирын толгод зэрэг газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 1151 орчим толгой тарваганы нөөцтэй байна. Дарьганга суманд 2019, 2022, 2023 онуудад Талын агуй, Баруун нарт уул зэрэг газруудад Хустайн нурууны БЦГ-аас сэлгэн нутагшуулсан байна.




Зураг 14. Дарьганга сумын монгол тарваганы тархац

Наран сумын Баянд улаан уул, Агуйт уул зэрэг газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 15 орчим толгой тарваганы нөөцтэй байна.




Зураг 15. Наран сумын монгол тарваганы тархац

Онгон сумын Онгон таван уул (Баруун бүс уул, Зүүн бүс уул, Хараат уул, Агуйт уул, Тээг уул) гэх газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 50 орчим толгой нөөцтэй байна.




Зураг 16. Онгон сумын монгол тарваганы тархац

Бидний судалгаагаар Халзан сумын Самын ухаа, Яргайт, Баян-уул, Цагаан бухт зэрэг газруудаар Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 180 орчим толгой тарваганы нөөцтэй байна. Халзан суманд 2019-2024 он хүртэл сүүлийн 5 жилд Самын ухаа, Яргайт, Баян-уул, Цагаан бухт зэрэг газруудад Хустайн нурууны БЦГ-аас сэргээн нутагшуулсан байна.




Зураг 17. Халзан сумын монгол тарваганы тархац

Баяндэлгэр сумын Шар даравгай, Овоон хар (Хар овоо), Тарам, Салаан хонд, Хонгор баг, Адуун нутаг, Шувуун хөндий зэрэг газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 238 орчим тарваганы нөөцтэй байна.




Зураг 18. Баяндэлгэр сумын монгол тарваганы тархац

Уулбаян сумын Үзүүр хараас Жонштойн хөр хүртэл Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 65 орчим тарваганы нөөцтэй байна. Уулбаян суманд 2023 онд Жонштын хөр гэх газарт Хустайн нурууны БЦГ-аас сэлгэн нутагшуулсан байна.



Зураг 19. Уулбаян сумын монгол тарваганы тархац

Мөнххаан сумын Шилийн холбоо урд хэсэг, Өлзийт овоо, Гутангийн айраг, Баянхаан уул, Богд уул, Мөнххаан уул Улаан асга, Баянцагааны тал зэрэг газруудад Монгол тарваганы тархацтай байгаа бөгөөд 422 орчим тарваганы нөөцтэй байна. Мөнххаан суманд 2019, 2022, 2024 онуудад Мөнххаан уул, Улаан асга, Баянцагааны тал зэрэг газруудад Хустайн нурууны БЦГ-аас сэлгэн нутагшуулсан байна.



Зураг 20. Мөнххаан сумын монгол тарваганы тархац

Сэргээн нутагшуулсан зарим нэг газарт монгол тарваганы бүлийн бүтэц хэвийн, үржлийн эрчим өндөртэй, мөндөл хотил зэрэг залуу бодгалиудын тоо толгой их байгаагаас цаашид улам бүр өсөх, байршил нутгаа тэлэх хандлагатай байгаа бол сэргээн нутагшуулсан зарим газрын тарвага шилжин байршсан байна.

Цаашид эдгээр сэргээн нутагшуулсан монгол тарвагыг хариуцан хамгаалах эзэнтэй болгох, өөрөөр хэлбэл орон нутгийн малчид ард иргэдийг байгаль хамгаалах нөхөрлөл бүлгэмийн зохион байгуулалтад оруулан уг амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар арга хэмжээг төлөвлөн явуулах нь тухайн нутгийн монгол тарваганы тоо толгой өсөн нэмэгдэх, байршил нутаг нь тогтворжиход чухал нөлөө үзүүлнэ. Түүнчлэн орон нутгийн ард иргэд, сургуулийн хүүхдүүдийн дунд сургалт сурталчилгааны ажлыг далайцтай зохион байгуулах, байгаль хамгаалагчдыг чадавхжуулах, ажиглалт, мониторинг судалгааг тогтмол явуулж хэвшүүлэх гэх мэт олон асуудлууд тулгарсаар байна.

ДҮГНЭЛТ

- Бидний 2024 оны 9-ээр сард хийсэн судалгаагаар 2733 орчим тарвагатай болох нь тогтоогдсон.
- Аймгийн нийт нутаг дэвсгэрийн тарваганы тархацтай 10 сумын нийт 6899.2 га талбайд 2733 толгой тарваганы нөөцтэй байна.
- Тус тархац талбай дах 523 бүлээс тарваганы бүлд ногдох тоог 114 бүлээс ажиглахад 558 тарвага тэмдэглэгдсэн байна.
- 10 га талбайн нэгжид 4.2 бүл ба нэг бүлд дунджаар 4.6 бодгаль амьтнаар тогтоогдсон үзүүлэлттэй гарсан.
- Түмэнцогт сумын Хар ямаатын Чонотын ам, Лхүмбэ багаас нэлээд урд хэсэг газарт, Сүхбаатар сумын Хар ганга, Эрдэнэцагаан сумын Зотол хаан уул, Дарьганга сумын Шилийн богд, Халзан сумын 1-р багийн нутагт тарвага өсөлттэй байна.
- Сүхбаатар аймгийн зарим сумдын нутагт 1980-1984 онд 1000 га тутамд хамгийн цөөн бага хэмжээ нь 35-45, дээд хэмжээ нь 150-200 амьтнаар тус тус тэмдэглэгддэг байсан бол одоо 0.004 амьтнаар тооцогдох болсон байна.
- Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга, Халзан, Уулбаян, Мөнххаан зэрэг 7 суманд 2019 оноос хойш нийтдээ 780 орчим монгол тарвага нутагшуулсан байна.
- Нутагшуулсан тарваганы өсөлт үржил, нутагшилт сайн байгаа бөгөөд аймгийн хэмжээн дэх тарваганы нөөцийн тодорхой хувийг эзэлж байна.
- Зарим монгол тарваганы тархац бүхий нутагт хавх, машины ул мөр ихээр ажиглагдаж байгаа тул тарваганы хууль бус агнуурт (Хар ганга, Шар даравгай) өртөж байгааг анхаарах шаардлагатай.
- Тарваганы баялаг нөөцтэй байсан газар уул уурхай, газар тариалан, хөдөө аж ахуй, мал аж ахуй эрчимтэй хөгжүүлэх, малын тоо толгой хэт өсөж малын бэлчээр, малчдын суурьшил тарваганы тархац нутгийг эзэмших болсноор тарваганы амьдрах зохилдлогоо алдагдана.



ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Аймаг, сум орон нутгийн хэмжээнд монгол тарвага хамгаалахын тулд урьдчилан тарваганыхаа тархац, байршил тоо толгойн үнэлгээг судлуулж тогтсоны үндсэн зорилго нь цаашид хамгаалах, өсгөж үржүүлэх ажлын гол суурь чиг зорилго, менежментийн төлөвлөлт хийх баримжаа үзүүлэлт тулгарч гарч ирдэг. Үүнд:

1. Эрдэм шинжилгээ, агнуур зохион байгуулалт, агнуурын амьтдын судалгааны материалд үндэслэсэн төлөвлөлтийн дагуу ажлыг зохион байгуулдаг зарчмыг хатуу мөрдөн ажиллах.
2. Агнуурын эдэлбэр нутаг, тарвага тархсан газрын эзэнгүйдэл, байршил нутгийн талхигдал, хомсдол, ахуйн хэрэгцээ, аж ахуйн хэрэглээний дарангуйлан эзэмшин ашиглахыг арилгаж багасгах, өмчийн олон хэлбэрийг нэвтрүүлэх.
2. Тарвага тархац бүхий нутгийг хамгаалах асуудлыг сум, багийн удирдлага өөрийн мэдэлд авч хамгаалалтын арга хэмжээний зардлыг жил бүрийн төсөвт суулгаж байх.
3. Тарваганы тархац тогтоогдсон нөөц бүхий газарт хамгаалалтын бүс тогтоон хариуцах эзнийг тухайн нутагт амьдардаг хүн томилж ажлыг нь үнэлж урамшил, цалинг олгож байх.
4. Тарваганы нөөцийг жил бүрийн 7-аар сарын 1-ээс 15-ны хооронд тоолох баг бүрэлдэхүүн гаргаж өсөлт, үржил, тоо толгойн хэмжээг тогтоож хамгаалалтын арга хэмжээнд үнэлэлт өгдөг байх.
5. Тарваганы тархац нутгийн аль өгөөжтэй, нөөц элбэгтэй газарт аль ашигтай салбарыг хөгжүүлэх, сэргээн нутагшуулах ажлыг дэс дараатай тогтооход мэргэжлийн байгууллагатай хамтрах, зөвлөгөө авах, тарвага нүүлгэн шилжүүлэх, сэргээн нутагшуулахад аль болох хүн, мал, аж ахуйн хэрэглээний газраас зайтай онгон зэлүүд, өвс ургамал сайтай, хад чулуу багатай зөөлөн элсэрхэг бус хар шороон хөрстэй, тарвага тархсан газар тохиромжтойг анхаарах.
6. Тарвага ичих буюу ичээнээс гарах үед тухайн орчинд айл, мал (нохой) ахуйн үйлчилгээг түр хугацаагаар явуулахгүй байх нь үржил явагдах, төллөх, ноохой зөөх, үүр байраа засах, шилжин байрших хөдөлгөөнд саад учирч идэш тэжээл бэлчээрлэлт хор нөлөө давамгайлснаар амьдрах чадвар доройтсоноос үр төлийн хорогдол их байдаг.
7. Устахад хүрч ганц хоёр үлдсэн бүл тарвагыг авран хамгаалж яаралтай тархцын бүлд нийлүүлж сэлгэн нутагшуулах шаардлагатай. Үүнд: Түмэнцогт сумын Баян-Овоо уулын 1 бүлийг Наран сумын Баян дулаан уулын бүдүүн толгойн 2 бүлийг нүүлгэх буюу нэмж тарвага тавих арга хэмжээ авах.
8. Дээрх санал дүгнэлт болгосон ажлыг хийлгэхэд амьтан судлаач агнуур зүйч, экологич, биологич зэрэг мэргэжлийн боловсон хүчнээр хангаж ажиллахыг шийдвэрлэх.

9. Байгаль хамгаалагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлж тэдэнд ажлын шаардлагатай материаллаг бүх зүйлээр хангаж байх.
10. Тарвага 7,8 сард тарга тэвээрэг авч таргалсан үедээ зусаал нүхэндээ хотил, шар хацар, сувай тарч, мөндөл, залуу бодгалиуд цуглардаг учир эпизотын халдвар авч болох үе байдгийг анхаарах.

Сүхбаатар аймгийн монгол тарваганы мониторинг судалгааг жилд 1-2 удаа хийх шаардлагатай. Хууль бус агнуурыг илрүүлэх, багасгах, амьдрах орчныг сайжруулах, тарваганы тархац бүхий газруудад идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах, мэдээллийн сан үүсгэж цаашдын хамгааллын төлөвлөгөө боловсруулах зорилгоор мониторинг судалгаа хийхэд жилд дунджаар **14 200 000** (арван дөрвөн сая хоёр зуу) төгрөг зарцуулахаар тусгаж байна.

Хүснэгт 7. Тарвага хамгаалах төлөвлөгөөний төсөл 1 жилээр

Хийгдэх ажил	Хугацаа ба давтамж	Баримтлах арга, аргачлал	Нийт зардал,төгрөг	Талуудын оролцоо
Орон нутгийн иргэдэд экологийн боловсрол олгох сургалт сурталчилгаа хийх, хэвлэмэл хуудас тараах	Жилд 1 удаа	Тарваганы байгаль экологид үзүүлэх нөлөөллийг таниулах	1.0	БОГ, ЕБС, бусад
Тарваганы байршил бүхий газруудад хөдөлгөөн мэдрэгчтэй камер байрлуулах	Жилд 2 удаа 4 болон 9 сард	Судалгааны бусад арга зүй ашиглаж болно	2.0	Байгаль орчны мэргэжилтэн, БОХУБ ,Байгаль хамгаалагч
Эргүүл шалгалт, хяналт хийх	Жилд 4 удаа 6-9 сард	Уламжлалт арга	8.0	Цагдаа, БОХУБ болон олон талын төлөөллийг оролцуулах
Тарваганы байршил бүхий газруудын хүн малын нөлөөг багасгах	Жилд 2 удаа 4 болон 9 сард	Тарваганы тархац бүхий газрын бэлчээрийг чөлөөлөх	2.0	Нутгийн иргэд, малчид
Тарваганы тархац бүхий газруудад идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулах	4-9 сар	Ажиглалт хийж, бүртгэл хөтлөх	1.2	Орон нутгийн малчин иргэд
ДҮН			14.2	

ТАЛАРХАЛ

Сүхбаатар аймгийн монгол тарваганы тархац, нөөцийн судалгааны хээрийн хайгуул, боловсруулалтын шатанд оролцож, зөвлөж, мэдээллээр хангаж тусалсан аймгийн ЗДТГ, БОАЖГ-ын дарга Ш.Нямхүү, биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн Б.Эрдэнэбаяр, Түмэнцогт сумын Засаг даргын орлогч Х.Гүрсоронзон, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчид, байгаль хамгаалагчид, орон нутгийн малчдад талархал илэрхийлж байна.

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Адъяа Я.,2007 Монгол тарвага, Улаанбаатар хот
2. Монгол улсын Амьтны тухай хууль, УБ хот, 2012
3. Монгол орны хөхтөн амьтны Улаан данс, УБ хот, 2006.
4. Тодгэрэл Т, Батболд Ж.,1998
Хустайн нурууны байгалийн нөөц газрын монгол тарвагыг судалсан дүнгээс. Тахь эрдэм шинжилгээний өгүүллүүд.
5. George Schaller
Into the wild of Mongolia
6. Susan E Townsend
Estimating Siberian marmot (*Marmota sibirica*) densities in the Eastern Steppe of Mongolia
7. Сүхбаатар аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны тайлан Эко үйлчилгээ ТББ, 2014.
8. Сүхбаатар аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны тайлан “Авралын Эрэлд” ХХК, 2021.

Сүхбаатар аймгийн монгол тарваганы тархац нөөцийн судалгаа

ХАВСРАЛТ 1. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ БҮРТГЭЛ

№	Сумдын нэр	Талбайн №	Тарвага тархсан газрын нэр	Нийт тархац талбай (га)	Тоологдсон бүл тарвага бүгд	Тарваганы тоог тогтоосон бүл	10 га-д оногдох бүл	Бүл дэх тарвага бүгд	Нэг бүлд оногдох	Бүгд тарваганы тоо
1	Түмэнцогт	S1	Түмэнцогт уул Хар ямаат Чонотын ам	780	38	4	0.48	28	7	266
		S2	Баян-овоо уул	2	1	1	5	4	4	4
		S3	Цэмүүл голын зүүн тал	1.5	2	2	13.3	6	3	6
		S4	Лхүмбэ баг (төмөртэй өндөр)	17	8	2	4.7	9	4.5	36
		S5	Багаас урагш бууцтай аманд Ногоон даваа орчим	9	6	2	6.6	11	5.5	33
2	Сүхбаатар	S1	Хар ганга хавцал толгой	97	21	4	2.1	23	5.7	121
		S2	Баян-овоо суваргатай	140	18	3	1.2	15	5	90
		S3	Уурхайн баруун	14	4	2	2.8	8	4	16
		S4	Уурхайн зүүн	2.5	4	1	16	3	3	12
		S5	Хонгор уул	30	9	1	3	3	3	27
3	Эрдэнэцагаан	S1	Чандмань уул	16	6	3	3.7	14	4.6	28
		S2	Хурангийн уул	15	7	3	4.6	12	4	28

Сүхбаатар аймгийн монгол тарваганы тархац нөөцийн судалгаа

№	Сумдын нэр	Талбайн №	Тарвага тархсан газрын нэр	Нийт тархац талбай (га)	Тоологдсон бүл тарвага бүгд	Тарваганы тоог тогтоосон бүл	10 га-д оногдох бүл	Бүл дэх тарвага бүгд	Нэг бүлд оногдох	Бүгд тарваганы тоо
		S3	Хурангийн уул баруун	40	9	2	2,2	11	5.5	49
		S4	Зотол хан уул	60	5	2	0.8	13	6.5	32
4	Дарьганга	S1	Шилийн богд хойд	150	7	5	0,4	19	3.8	26
		S2	Шилийн богд зүүн	75	9	7	1.2	31	4.4	39
		S3	Шилийн богд урд	8	6	2	7.5	9	4.5	27
		S4	Шилийн богд баруун	1000	162	18	1.6	91	5	819
		S5	Талын агуй	15	6	3	4	14	4.6	28
		S6	Талын ухаа	10	5	2	5	14	7	35
		S7	Нарт уул	6	6	1	10	4	4	24
		S8	Цавчир толгод	30	4	2	1.3	7	3.5	14
5	Наран	S1	Баян дулаан уул Агуйт уул	13	5	1	3.8	3	3	15
6	Онгон	S1	Онгон таван уул	4	5	1	12.5	3	3	15
		S2	Зүүн бүс уул	1	1	1	10	3	3	3
		S3	Хараат уул	4	5	1	12.5	6	6	30
		S4	Баруун бүс уул	1	1	1	10	3	3	3
7	Халзан	S1	Самын ухаа, Яргайт, Баян-уул	1202	49	10	2.7	37	3.8	180
8	Баяндэлгэр	S1	Шар даравгай	220	13	2	0.6	12	6	78

Сүхбаатар аймгийн монгол тарваганы тархац нөөцийн судалгаа

№	Сумдын нэр	Талбайн №	Тарвага тархсан газрын нэр	Нийт тархац талбай (га)	Тоологдсон бүл тарвага бүгд	Тарваганы тоог тогтоосон бүл	10 га-д оногдох бүл	Бүл дэх тарвага бүгд	Нэг бүлд оногдох	Бүгд тарваганы тоо
		S2	Овооны ар (хар овоо)	300	8	3	0.2	14	4.6	37
		S3	Тарам, салаан хонд, хонгор баг	1750	12	5	0.6	11	5.5	62
		S4	Адуун нутаг, шувуун хөндий	100	11	2	1.1	11	5,5	60
9	Уулбаян	S1	Үзүүр хараас жонштойн хөр	43	13	1	3	4	5	65
10	Мөнххаан	S1	Шилийн холбоон урд талд 2 хэсэг	30	5	1	1.6	4	4	20
		S2	Өлзийт овоо	420	28	4	0.6	41	10	287
		S3	Гутангийн айраг Баянхаан уул	10	4	1	4	2	3	12
		S4	Богд уул	48.2	9	4	1.8	19	4.7	42
		S5	Мөнххаан уул	225	8	3	0.3	16	5.3	42
		S6	Тарвага нүүсэн газар	10	3	1	3	6	6	18

ХАВСРАЛТ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОЖ МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН ХҮНИЙ НЭРС

№	Нэрс	Албан тушаал
1	Б. Эрдэнэбаяр	Аймгийн БОГ-н мэргэжилтэн
2	Х.Гүрсоронзон	Түмэнцогт сумын Засаг даргын орлогч
3	Ууганбаяр	Түмэнцогт сумын БХ
4	Ганбулган	Сүхбатаар сумын БХ
5	Амарбаясгалан	Эрдэнэцагаан сумын БХ
6	Сайханжаргал	Эрдэнэцагаан сумын иргэн
7	Шинэбаяр	Хилийн 1-р застав
8	Батдорж	Дарьганга сумын БХ
9	Алтангэрэл	Хилийн 7-р застав
10	Цолмон	Наран сумын БХ
11	Ган-Очир	Наран сум малчин
12	Болор-Эрдэнэ	Онгон сум малчин
13	Мөнхзул	Баяндэлгэр сум БХ
14	М.Хуяг	Халзан сумын БХ
15	Баасанжав	Халзан сум мануул суурин идэвхтэн БХ
16	Ренчин	Уулбаян сумын БХ
17	Дашдорж	Уулбаян идэвхтэн БХ
18	Гэрэлчимэг	Мөнххаан сумын БХ

ХАВСРАЛТ 3. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ҮЕИЙН ФОТО ЗУРАГ



Түмэнцогт сум. БХ Ууганбаяр



*Мөнххаан сум. БО-ны мэргэжилтэн
Эрдэнэбаяр, идэвхтэн байгаль
хамгаалагчийн хамт*



Хар ямаат БНГ



Сүхбаатар сум. Хар ганга



Дарьганга сум. Шилийн богд



Наран сум. Баян дулаан уул



Дарьганга сум. Шилийн богд



Онгон сум. Онгон таван уул



Халзан сум. Автомат камертай нүх



Эрдэнэцагаан сум. Хилийн нэгдүгээр застав.



Эрдэнэцагаан сум. Хурангийн уул



Дарьганга сум. Шилийн богд